



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/12

Арвайхээр

**Сар шинийн баяраар эмнэлгийн тусламж
үйлчилгээг зохицуулах тухай**

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 97.1.2 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн А/36 дугаартай “Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үед эрүүл мэндийн байгууллагын ажиллах нийтлэг журам”, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирлын 2020 оны А/50 дугаартай “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 3.1.1 дэх заалтын тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сар шинийн баяраар эмнэлгийн тусламж үйлчилгээг тасралтгүй хангах зорилгоор БОЭТ-д 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 2023 оны 2 дугаар сарын 27-ны өдөр хүртэлх хугацаанд ажиллах хариуцлагатай жижүүрүүдийн нэрсийг нэгдүгээр, жижүүр эмч, жолооч дуудагдах цусны банкны эмч, мэргэжилтэн, рентген техникч, лаборант нарын нэрсийг хоёрдугаар, сантехникийн слесарь, цахилгаанчин харуул нарын нэрсийг гуравдугаар, алсын болон ойрын дуудлагад явах эмч, жолооч нарын нэрсийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Баярын өдрүүдэд жижүүрийн эмч , ажиллагсдын ажлын хариуцлага, сахилга бат, анхаарал сулрах, ажлын байрыг орхиж явах, согтууруулах ундаа хэрэглэхээс урьдчилан сэргийлж, өмч хөрөнгийн бүрэн бүтэн, аюулгүй байдалд 3-аас доошгүй удаа эргэлт хяналт хийж, хариуцлагатай жижүүрийн тэмдэглэл хөтлөн мэдээ авч, ээлж хүлээлцүүлэн, шаардлагатай тохиолдолд /нийтийг хамарсан хордлого, осол гэмтэл, эмнэлгийн тусламж үйлчилгээний алдаа зөрчил/ Эрүүл мэндийн газрын болон Онцгой байдлын газрын хариуцлагатай жижүүр, Эмнэл зүй эрхэлсэн дэд захиралтай холбогдон шуурхай мэдээллээр хангаж ажиллахыг хариуцлагатай жижүүр Эмнэл зүй эрхэлсэн дэд захирал (Д.Болормаа), Ерөнхий санхүүч (Г.Ганчөдөр), Гүйцэтгэлийн удирдлага дотоод хяналтын албаны дарга (Д.Аззаяа), Эмнэлгийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын албаны дарга (Ц.Лувсандамдин), Поликлиникийн албаны эрхлэгч (Д.Цэцэгтуяа), Эрүүл мэндийн дэмжих төвийн дарга (Д.Энхбаатар), Сувилахуйн албаны дарга (Б.Тунсагбямба) нарт даалгасугай.

3.Жижүүрийн хугацаан дах жижүүрийн багийн үйл ажиллагааг зохицуулан эмнэлгийн тусламжийг шуурхай зохион байгуулж, жижүүрийн мэдээг хариуцлагатай жижүүрт нэгтгэн тэмдэглэл хөтөлж танилцуулахыг жижүүрийн ахлагч нарт үүрэг болгосугай.

4.Машин техникийн бүрэн бүтэн байдал, шатахууныг хангалттай хэмжээгээр нөөцөлж, жолооч, эмч, мэргэжилтэн, ажиллагсдын хувийн бэлтгэлийг хангуулахыг Ерөнхий санхүүч (Г.Ганчедөр), Хөдөлмөрийн аюулгүй байдал орчны эрсдэлийн менежер (Б.Эрдэнэзул) нарт үүрэг болгосугай.

5.Үйлчлүүлэгчдэд үзүүлэх яаралтай тусламж, осол гэмтэлд авах арга хэмжээнд зориулсан ороох боох материал, эм,эмнэлгийн хэрэгсэл, цус цусан бүтээгдэхүүн -г нөөцийг бүрдүүлэн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Эм зүйн албаны дарга (Ц.Мөнгөнтуяа)-д Цусны салбар төвийн эрхлэгч (Н.Долгорсүрэн) нарт үүрэг болгосугай.

6.Байгууллагын дотоод журамд заасан цагийн, хуваарийг нарийн баримталж, удирдах ажилтнууд, клиник, албадын эрхлэгч, ахлагч нар, нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтнүүд, ажиллагсад гар утсаа байнгын нээлттэй байлгаж, дуудсан тохиолдолд шуурхай ирж ажиллахыг үүрэг болгосугай.

7.Хүнд өвчтөн, жирэмсэн эмэгтэй, эх нярай хүүхдэд үзүүлэх тусламжийг онцгой анхаарч эмнэлгийн тусламж үйлчилгээг хүлээгдэл чирэгдэлгүй шуурхай үзүүлэх, эмч нарын зөвлөгөөнийг хугацаа алдалгүй хийх, тусламж үйлчилгээний эмнэл зүйн удирдамж, стандартыг чанд мөрдөх, мөрдөж, алдаа, зөрчил гарахаас сэргийлж ажиллахыг нийт жижүүрт гарч байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажиллагсад, Эмнэл зүй эрхэлсэн дэд захирал (Д.Болормаа) нарт үүрэг болгосугай

8.Баярын үеэр согтууруулах ундаа хэрэглэхгүй байх, гэмтэх, осгож хөлдөх, гэмт хэрэг зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлж ажиллахыг нийт эмч эмнэлгийн мэргэжилтэн, ажиллагсад анхааруулсугай.

ЗАХИРАЛ



Г.ДАШЖАНЦАН